

**БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2024 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨЛ**

2023 ОН

НЭГ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГЫН ОНЦЛОГ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

1. Шинэ сэргэлтийн бодлого – Хот, хөдөөгийн сэргэлт.

Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллаж төрийн үйлчилгээг саадгүй, хүртээмжтэй хүргэх болон орон сууцанд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2024 оны төсвийн жилд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

- ✓ **Орон нутгийн нэмэгдэл олгоно.** Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2023 оноос олгож эхэлсэн орон нутгийн нэмэгдлийн хувь хэмжээ болон хамрах хүрээг нэмэгдүүлнэ. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 4 дүгээр сараас эхлэн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчид 40 хувь, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчид 20 хувийн нэмэгдлийг авдаг болно.
- ✓ **Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олгоно.** 2024 оноос орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгож эхэлнэ.

2. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.

2024 оны 4 дүгээр сараас эхлэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ. Нийтлэг үйлчилгээ болон тохижилт үйлчилгээний салбарын ажилчдын цалинг 20 хувь нэмэгдүүлэх бол түүнээс бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлнэ.

3. Ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлж, эдийн засгийн баталгааг хангана.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч нийт 516.8 мянган ахмадын тэтгэврийг ирэх 4 дүгээр сараас эхлэн сар бүр 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлнэ. Нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 440.0 мянган төгрөг, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 550.0 мянган төгрөг байгааг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 540.0 мянган төгрөг, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 650.0 төгрөг болж нэмэгдэнэ.

4. Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлнэ.

Ирэх 2024 оны төсөвт шинээр батлагдсан нийгмийн даатгалын багц хуульд тусгагдсан дараах арга хэмжээнүүдийг бүрэн санхүүжүүлэх зардлыг тусгасан.

5. Багш ажилчдын нийгмийн баталгааг сайжруулах болон багш бэлтгэхтэй холбоотой бодлогын дараах арга хэмжээний зардлыг ирэх 2024 оны төсөвт бүрэн тусгалаа.

6. Уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд татварын бодлогын дэмжлэг үзүүлнэ.

Уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татвар

төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, хэсэгчлэн төлүүлэх боломжийг олгоно.

7. Хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, үнэт цаасны зах зээлийг татварын бодлогоор дэмжинэ.

Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлээр үе шаттай хэрэгжүүлж буй бодлогыг өргөжүүлэн үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагдаж буй хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод 2029 он хүртэл татварын хөнгөлөлт үзүүлэхээр, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад татварын ялгаатай дэглэм үйлчилж байгааг өөрчилж олон улсын жишгээр ижил зарчмаар татвар тооцдог болсноор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

8. Малчид орлогын, НӨАТ, малын тоо толгойн албан татвар тайлан боловсруулах, тушаах үүргээс чөлөөлөх, НӨАТ суутган төлөгч болох шаардлагагүй болгох замаар татварын орчныг хялбаршуулан, малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулж, боловсруулах үйлдвэрүүдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлнэ.

9. Хөгжилд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ.

10. Байгалын баялгийн өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлнэ.

Уул уурхайн орлогын тодорхой хувиас бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал санаачилга дээр тулгуурлан, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн Орон нутгийн хөгжлийн сангаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймгуудад нэмэлтээр хуваарилагдаж, үүнээс сумдад олгох санхүүжилтийг 60 хувьд хүртэл нэмэгдүүлнэ. Ингэснээр тогтвортой, хариуцлагатай уул уурхайг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулан, байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх боломж бүрдэнэ.

ХОЁР. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Төсвийн орлогын төлөвлөлт

Төсвийн орлогын 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 6 жилийн судалгаа зэрэгт үндэслэн 48.7 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Хувь хүний орлогын албан татвар

- Цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвараар 2023 онд 8.0 тэрбум төгрөг төлөвлөсөн ба 80.0 хувийг төр төсвийн байгууллагад ажиллагсдын цалин хөлсний орлого болон түүнтэй адилтгах орлогын албан татвараас бүрдэж байгаа бөгөөд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 100 хувь биелэхээр байна. Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлт, цалингийн тогтолцооны шинэчлэлт, Сангийн яамнаас тооцсон суурь орлогын хүрээнд 2024 онд цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг хянасан суурь орлогыг 20 хувиар өсгөж 10.2 тэрбум төгрөгөөр тооцлоо.
- ХААН банк, Төрийн банк, Хас банк банкин дахь хадгаламж эзэмшигч иргэдийн судалгаанд үндэслэн хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулж хөрөнгийн орлогыг бүрдүүлэхээр 700.0 сая төгрөг төлөвлөж, сумдад хуваариллаа.
- 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс шинэчлэгдэн баталж хэрэгжиж байгаа хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар хуулийн этгээд хувиараа бараа материал бэлтгэх, үйлчилгээ үзүүлсний орлогод 10 хувийн татвар суутган төсөвт төвлөрүүлдэг байсан зүйл заалт хүчингүй болсноор сангийн яам суурь орлогыг бууруулж 78 сая төгрөгөөр төлөвлөлөө.
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтоор 2023 онд 756 иргэнд 611.8 сая төгрөгийг олгосон. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлтөөр 2021 оноос татварын буцаан олголтоор 6.0 сая хүртэл төгрөгийг авах боломжтой болсонтой холбогдуулан 2024 онд 750.0 сая төгрөг олгохоор тооцлоо.

Хүснэгт № 01. 2020-2024 оны хувь хүний орлогын албан татварын
буцаан олголтын судалгаа (сая.төг)

№	Үзүүлэлт	2020 гүйц	2021 гүйц	2022 гүйц	2023 гүйц	2024 төлөвлөгөө
1	Хүний тоо	1213	804	816	756	1250
2	Олгосон дүн (сая.төг)	473.0	416.6	471.2	611.8	750.0

Хөрөнгийн албан татвар

Хөрөнгийн албан татварын орлогод үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг хамааруулж, нийт 4,234.2 сая төгрөгөөр төлөвлөв. Бүтцийн хувьд авч

үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 3,713.2 сая төгрөг буюу 87.4 хувь, бууны албан татварын орлого 62.0 сая буюу 1.5 хувь, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 460.0 сая буюу 11.1 хувийг эзэлж байна. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын өмнөх жилүүдийн өрийг барагдуулах чиглэлээр судалгаа, тооцоо гаргаж мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж байгаа тул тухайн орлогыг 60 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн. Галт зэвсгийн албан татварыг цагдаагийн газрын галт зэвсгийн бүртгэлийг үндэслэн 62 сая төгрөгөөр төлөвлөсөн. 2022 онд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоож уул уурхай үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд 2 хувиар албан татвар ноогдсоноор энэ төрлийн орлого нэмэгдэж 3,713.1 сая төгрөгөөр төлөвлөсөн.

Бусад татвар, төлбөр хураамж

Төрийн эрх бүхий байгууллагаас “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа тэмдэгтийн хураамжийн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлд үндэслэн 202.4 сая төгрөгөөр тооцов.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хураамжийн орлогыг босоо тэнхлэгийн авто замын ажилтай холбогдуулан 80.0 сая төгрөгөөр төлөвлөлөө.

2024 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоосон үнэлгээг харгалзан, сумын төвийн өрхийн 90.0 хувиар тооцон 379.5 сая төгрөгөөр төлөвлөв. Цаашид сумын Засаг дарга түүний тамгын газрын холбогдох албан тушаалтнууд “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу хогны менежментийг боловсронгуй болгон айл өрх, албан байгууллагуудаас авах хог хаягдлын хураамжийн орлогыг нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан тогтоож мөрдөх шаардлагатай байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан “Газрын төлбөрийн бааз” болон “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-д тусгасны дагуу газрын төлбөрийн орлогыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран тооцож 1805.7 сая төгрөгийг тус орлогын төлөвлөгөөнд тусгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тушаалын дагуу ойгоос бэлтгэж ашиглах хэрэглээний мод бэлтгэх хуваарийг үндэслэн 2024 оны ойн нөөц ашигласны төлбөр өсөж 500.9 сая төгрөгөөр төлөвлөлөө. Мөн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2023 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл гадаадын аялал жуулчлалын урсгал, ангийн зөвшөөрлийн эрхийн бичгийн олголт зэргийг харгалзан 31.0 сая төгрөг болгон төлөвлөлөө. Ус ашигласны төлбөрийн орлогыг 27.9 тэрбум төгрөгөөр төлөвлөж байна.

ГУРАВ. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ

Төсвийн зарлагын талаар

Орон нутгийн төсвийн байгууллагын төсвийг Сангийн яамнаас хянасан суурь зардал, сүүлийн жилүүдийн төсвийн гүйцэтгэл, 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд үндэслэн тооцооллыг хийлээ.

2024 оны төсвийн жилд урсгал төсвийн урсгал зарлагатай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор Худалдан авах ажиллагааны газар байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотой аймгийн Засаг даргын 2023 оны А/765 дугаар захирамжаар Худалдан авах ажиллагааны газар байгуулж, дүрэм, бүтэц орон тоог, А/764 дугаар захирамжаар Орон нутгийн өмчийн газрын дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Агентлаг шинээр байгуулагдаж, бүтэц өөрчлөгдөж байгаатай холбоотой нэмэлтээр шаардагдах цалин, нийгмийн даатгалын шимтгэл үйл ажиллагааны зардлыг тооцон тусгалаа.
- Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж 2024.01.01-с сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохоор заасан. Үүний дагуу суманд ажиллаж байгаа 137 төрийн захиргааны албан хаагчид 1095.8 сая төгрөгийг олгохоор тооцож тусгасан. Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасны дагуу дээрх мөнгөн урамшууллыг олгох журмыг Засгийн газар батална гэж заасан тул Засгийн газрын тогтоолоор журам батлагдсаны дараа хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох ажлыг эхлүүлнэ.
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдөхөөр хүсэлт гаргасан долоон төрийн албан хаагчид нийт 173.5 сая төгрөгийн тэтгэмжийг Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тооцож тусгасан.
- 2024 оны суурь орлого, зардалд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөд 220.6 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 595.7 сая төгрөг нийт 816.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээр туссаныг бууруулахгүйгээр тооцож тавьсан.
- Засгийн газрын 2023 оны 312, 378 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарт өөрчлөлт орж орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтний орон шинээр нэмэгдэж, “Залуучуудын хөгжлийн төв”-ийн 3 орон тоо шилжин ирж нийт 4 орон тоог нэмэгдэж байгаа тул шаардагдах цалин, нийгмийн даатгалын шимтгэл үйл ажиллагааны зардлыг тооцон тусгалаа.

- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу орон нутгийн суурь зардалд тусгагдсан улсын төсвийн байгууллагуудын байр ашиглалтын зардлын тооцооллыг хийж 11,791.8 төгрөгийг тооцож тусгалаа. 2024 оны төсвийн жилд аймгийн Нэгдсэн эмнэлэг, ерхийн эрүүл мэндийн төвийн байр ашиглалтын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуульд өөрчлөлт орж байгаатай холбоотой шаардагдах зардлыг тооцсон.
- Засгийн газар 2024 оны 04 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Нийтлэг үйлчилгээ болон тохижилт үйлчилгээний салбарын ажилчдын цалинг 20 хувь нэмэгдүүлэх бол түүнээс бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэн тооцооллыг хийсэн.
- Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2023 оны төсвийн жилээс эхэлсэн орон нутгийн нэмэгдлийн хувь хэмжээ болон хамрах хүрээг нэмэгдүүлж, 2024 оны 04 дүгээр сараас эхлэн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчид 40 хувь, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчид 20 хувийн нэмэгдлийг олгохоор төсвийн тооцооллыг хийлээ.
- Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолд нэмэлт орж (Засгийн газрын 2023 оны 242 тогтоол) орон нутагт ажилласны нэмэгдлийг орон нутгийн төсвийн байгууллагын 309 төрийн захиргааны албан хаагчид 1,620.8 сая, улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчид 80 хүртэл хувиар нэмж олгохыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтөө тусган шийдвэрлэнэ гэж заасны дагуу 337 төрийн захиргааны албан хаагчид 890.0 сая төгрөгийг олгохоор тооцоолж тусгалаа.
- 2024 онд Булган аймагт зохион байгуулагдах “Алтаргана” олон улсын наадмын үйл ажиллагааны зардалд 1,800.0 сая төгрөгийг тооцсон.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVI/16 дугаар тогтоолоор газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаанаас орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын 10 хувийг газар зохион байгуулалтын болон бэлчээрийн менежмент хийх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх, дуудлага худалдаа явуулах, программ хангамжийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, албан хаагчдыг чадавхжуулах арга хэмжээнд зарцуулахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолын дагуу 30.0 сая төгрөгийг тооцож тусгалаа.
- Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын дагуу “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу сумын төсөвт төвлөрүүлэх орлогын хэсгээр санхүүжих байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 735.4 сая төгрөгийг сумын суурь зардалд тусгасан.

2024 оны төсвийн тооцоонг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт №02. Аймгийн шууд харьяа байгууллагуудын төсвийн тооцоо

(мянган төгрөг)

Д/д	Байгууллагын нэр	2024 оны төсвийн төсөл
1	Аймгийн ИТХ	1,135,430.4
2	Аймгийн ЗДТГ	4,079,432.6
3	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	735,000.0
4	Санхүүгийн хяналт, аудитын алба	394,868.4
5	Орон нутгийн өмчийн газар	251,738.3
6	Худалдан авах ажиллагааны газар	206,005.2
7	Байгаль орчин аялал жуулчлалын газар	1,470,458.7
8	Хүүхдийн сувилал	308,182.5
9	Хотын нийтийн хүн тээвэр	12,000.0
10	Халамжийн сан	108,700.0
11	Гамшгаас хамгаалах сан	100,000.0
12	Цэргийн дүйцүүлэх алба	180,000.0
13	Цэвэрлэх байгууламж	400,000.0
14	Дамжуулан олгосон зээлийн төлбөр, хүүгийн төлбөр	816,293.5
15	Ахмадын хороо	139,276.0
16	Мал эмнэлгийн үйлчилгээ	746,704.8
17	Улсын төсвийн байгууллагын байр ашиглалтын зардал	2,571,078.6
18	УТБ-ын Төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл	890,000.0
	Нийт дүн	14,545,168.9

Суманд олгох санхүүгийн дэмжлэг

Суурь зардалд орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, ойн анги, тохижилт үйлчилгээний ангийн зардал, байр ашиглалт болон үйлчилгээний зардал, байгаль нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тооцоолсон.

Суманд олгох санхүүгийн дэмжлэгийг суурь зардал, суурь орлогын зөрүүгээр тооцоолсон ба 13 сум, 1 тосгонд 15,741.9 сая төгрөгийг олгож, 3 сумаас 1,349.2 сая төгрөгийг төвлөрүүлж авахаар байна.

Хүснэгт №03. 2024 оны суманд олгох санхүүгийн дэмжлэг

(мянган төгрөг)

№	СУМЫН НЭР	СУУРЬ ЗАРДАЛ	СУУРЬ ОРЛОГО	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ
1	Баян-Агт	1,694,184.1	391,815.2	1,302,368.9
2	Баяннуур	1,335,490.1	319,290.9	1,016,199.2
3	Бугат	1,452,455.3	276,985.8	1,175,469.5
4	Булган	5,447,741.5	6,557,766.2	
5	Бүрэгхангай	1,690,084.2	1,804,937.6	

6	Гурванбулаг	1,633,042.4	350,933.7	1,282,108.7
7	Дашинчилэн	1,491,955.2	411,288.6	1,080,666.6
8	Могод	1,542,513.5	324,583.3	1,217,930.2
9	Орхон	1,581,397.3	647,862.2	933,535.1
10	Рашаант	1,729,514.3	865,313.1	864,201.1
11	Сайхан	1,479,059.0	346,391.9	1,132,667.1
12	Сэлэнгэ	1,853,545.1	503,203.2	1,350,341.9
13	Тэшиг	1,781,062.4	957,280.5	823,781.8
14	Хангал	1,460,526.1	3,464,676.4	
15	Хишиг-Өндөр	1,769,202.3	423,150.6	1,346,051.8
16	Хутаг-Өндөр	2,241,487.9	1,037,912.6	1,203,575.3
17	Хялганат	1,591,065.0	578,016.9	1,013,048.1
	Сумын дүн	31,774,325.8	19,261,408.9	15,741,945.4

Булган, Бүрэгхангай, Хангал сумын төсвийн үндсэн тэнцлийн ашгаас Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 хэсэгт заасны дагуу аймгийн төсөвт төвлүүлэх орлогыг тооцоолсон.

Хүснэгт №04. 2024 онд сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ
(мянган төгрөг)

№	СУМЫН НЭР	Үндсэн тэнцэл	Суманд үлдэх	Аймагт төвлөрүүлэх
1	Булган	1,110,024.7	777,017.3	333,007.4
2	Бүрэгхангай	114,853.5	80,397.4	34,456.0
3	Хангал	2,004,150.3	1,022,368.3	981,782.0
	Дүн	3,229,028.5	1,879,783.0	1,349,245.5

Орон нутгийн хөгжлийн сан

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 13,601.6 сая төгрөгөөр батлагдсан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуультай хамт Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан ба орон нутгийн хөгжлийн сангийн итгэлцүүрт үндэслэх тооцоолол, эх үүсвэрт өөрчлөлт орсон.

Хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр тооцоолол хийхэд суманд орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр нийт 8,630.9 сая төгрөгийг олгож, аймгийн орон нутгийн хөгжлийн санд 4,970.7 сая төгрөг хуваарилагдана.

Хүснэгт №05. 2024 оны сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоолол

(мянган төгрөг)

№	Сумын нэр	Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Сумын ОНХС-д хувиарлагдах дүн
1	Баян-Агт	294,758.6	-	-	-	294,758.6
2	Баяннуур	217,157.5	-	4,306.0	11,364.0	232,827.5

3	Бугат	266,903.7	41,065.0	12,681.0	1,525.0	322,174.7
4	Булган	516,177.7	-	-	-	516,177.7
5	Бүрэгхангай	952,598.5	-	56,094.0	127,396.0	1,136,088.5
6	Гурванбулаг	291,854.5	64,005.0	-	1,327.0	357,186.5
7	Дашинчилэн	575,238.9	59,783.0	-	60,915.0	695,936.9
8	Могод	253,007.5	55,172.0	75.0	-	308,254.5
9	Орхон	1,345,154.5	-	8,239.0	162,810.0	1,516,203.5
10	Рашаант	180,385.3	-	-	-	180,385.3
11	Сайхан	365,837.3	-	11,110.0	4,836.0	381,783.3
12	Сэлэнгэ	511,761.5	78,002.0	5,072.0	23,074.0	617,909.5
13	Тэшиг	676,277.3	121,556.0	-	24,114.0	821,947.3
14	Хангал	266,645.6	82,343.0	878.0	-	349,866.6
15	Хишиг-Өндөр	249,769.8	48,091.0	117.0	98.0	298,075.8
16	Хутаг-Өндөр	492,488.8	108,879.0	-	-	601,367.8
	НИЙТ ДҮН	7,456,017.0	658,896.0	98,572.0	417,459.0	8,630,944.0

**БУЛГАН АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСӨВ
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн 2024 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

	Аймгийн төсвийн орлого, тусламжийн дүн	29,949,331.0
1	Аймгийн төсвийн орлого бүгд	29,949,331.0
1.1	Татварын орлого	28,284,300.0
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-750,000.0
1.1.2	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	725,000.0
1.1.3	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	0.0
1.1.4	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	460,000.0
1.1.5	Улсын тэмдэгтийн хураамж	15,000.0
1.1.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус ашигласны төлбөр	27,834,300.0
1.2	Татварын бус орлого	1,635,031.0
1.2.1	ОНӨ-ийн эд хөрөнгийг ашигласны төлбөр	2,000.0
1.2.2	Газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт	301,000.0
1.2.3	Хүүгийн орлого	595,693.5
1.2.4	Торгуулийн орлого	69,737.5
1.2.5	Төсөвт байгууллагын өөрийн орлого	466,600.0
1.2.6	Нэр заагдаагүй бусад орлого	200,000.0
1.3	Хөрөнгийн орлого	30,000.0
1.3.1	Хөрөнгө борлуулсны орлого	30,000.0

Хоёр. Аймгийн 2024 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

Д/д	ТӨЗ, түүний харьяа байгууллага	Орлогын дүн
2.1	Аймгийн Засаг дарга	466,600.0
2.1.1	Аймгийн ЗДТГ-ын өөрийн орлого	10,000.0
2.1.2	Худалдан авах ажиллагааны газар	6,000.0
2.1.3	Цэргийн дүйцүүлэх албаны төлбөрийн орлого	180,000.0
2.1.4	Дамжуулан олгох зээлийн эргэн төлөх төлбөр	220,600.0
2.1.5	Биеийн тамир спортын газар	50,000.0

Гурав. Аймгийн 2024 оны төсвийн жилд төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 60,594,776.0 мянган төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай.

(мянган төгрөг)

3.1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	1,135,430.4
3.1.1	Урсгал зардлын дээд хэмжээ Үүнээс: Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1,009,430.4
3.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	126,000.0
3.2	Засаг дарга	59,459,345.7
3.2.1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	4,729,432.6
3.2.1.1	Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ	15,741,945.4
3.2.1.2	Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	8,630,944.0
3.2.1.3	Орон нутгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал	2,571,078.6
3.2.1.3.1	Номын сан	34,019.6
3.2.1.3.2	Музей	54,422.0
3.2.1.3.3	Хөгжимт жүжгийн театр	99,800.0
3.2.1.3.4	Булганхангай МСҮТ	78,513.8
3.2.1.3.5	ХАА-н МСҮТ	439,805.0
3.2.1.3.6	БТСГазар	563,518.2
3.2.1.3.7	Нэгдсэн эмнэлэг	1,301,000.0
3.2.1.2	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	18,637,175.8
3.2.1.2.1	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх их засвар	2,876,194.0
3.2.1.2.2	Авто замын сан	1,108,500.0
3.2.1.2.3	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	9,681,803.8
3.2.1.2.4	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	4,970,678.0
3.2.2	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	394,868.4
3.2.3	Орон нутгийн өмчийн газар	251,738.3
3.2.4	Худалдан авах ажиллагааны газар	206,005.2
3.2.5	Байгаль орчин аялал жуулчлалын газар	1,470,458.7
3.2.6	Хүүхдийн сувилал	308,182.5
3.2.7	Нийгмийн халамжийн сангийн зардал	108,700.0
3.2.8	Гамшгаас хамгаалах сангийн зардал	100,000.0
3.2.9	Цэргийн дүйцүүлэх албаны зардал	180,000.0
3.2.10	Нийтийн тээврийн татаас	12,000.0
3.2.11	Мал эмнэлгийн үйлчилгээний зардал	746,704.8
3.2.12	Төрийн албан хаагчдад олгох тэтгэмж	544,542.0
3.2.13	Ахмадын хорооны зардал	139,276.0
3.2.14	Аймгийн Засаг даргын хуулиар олгогдсон зарим чиг үүргийг хэрэгжүүлэх зардал	150,000.0
3.2.15	Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	600,000.0
3.2.16	Алтаргана наадам зохион байгуулах зардал	1,800,000.0
3.2.17	Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны орлогын 10 хувь	30,000.0
3.2.18	Дамжуулан олгох зээлийн үндсэн төлбөр	220,600.0
3.2.19	Дамжуулан олгох зээлийн хүүгийн төлбөр	595,693.5
3.2.20	Цэвэрлэх байгууламжийн зардал	400,000.0
3.2.21	Улсын төсвийн харьяа байгууллагын төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдэлд олгох зардал	890,000.0

Дөрөв. Аймгийн 2024 оны төсвийн жилд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 18,637,175.8 мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Аймгийн 2024 оны төсвийн жилд аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

5.1	Сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	15,741,945.4
5.1.1	Баян-Агт	1,302,368.9
5.1.2	Баяннуур	1,016,199.2

5.1.3	Бугат	1,175,469.5
5.1.4	Гурванбулаг	1,282,108.7
5.1.5	Дашинчилэн	1,080,666.6
5.1.6	Могод	1,217,930.2
5.1.7	Орхон	933,535.1
5.1.8	Рашаант	864,201.1
5.1.9	Сайхан	1,132,667.1
5.1.10	Сэлэнгэ	1,350,341.9
5.1.11	Тэшиг	823,781.8
5.1.12	Хишиг-Өндөр	1,346,051.8
5.1.13	Хутаг-Өндөр	1,203,575.3
5.1.14	Хялганат	1,013,048.1

Зургаа. Аймгийн 2024 оны төсвийн жилд сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

6	Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого	1,349,245.4
6.1.1	Булган	333,007.4
6.1.2	Бүрэгхангай	34,456.0
6.1.3	Хангал	981,782.0

Долоо. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

7.1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан нийт:	13,601,622.0
7.1.1	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилах дүн	4,970,678.0
7.2	Нийт суманд хуваарилах дүн	8,630,944.0
7.2.1	Баян-Агт	294,758.6
7.2.2	Баяннуур	232,827.5
7.2.3	Бугат	322,174.7
7.2.4	Булган	516,177.7
7.2.5	Бүрэгхангай	1,136,088.5
7.2.6	Гурванбулаг	357,186.5
7.2.7	Дашинчилэн	695,936.9
7.2.8	Могод	308,254.5
7.2.9	Орхон	1,516,203.5
7.2.10	Рашаант	180,385.3
7.2.11	Сайхан	381,783.3
7.2.12	Сэлэнгэ	617,909.5
7.2.13	Тэшиг	821,947.3
7.2.14	Хангал	349,866.6
7.2.15	Хишиг-Өндөр	298,075.8
7.2.16	Хутаг-Өндөр	601,367.8

Найм. Монгол улсын төсөвт 2024 онд дор дурдсан зээлийн эргэн төлөх үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр төлсүгэй.

(мянган төгрөг)

Д/д	Төслийн нэр	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	Барилга хот байгуулалтын салбарын зээл	220,600.0	595,693.5

Ес. Аймгийн 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 60,594,776.0 мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай.

1. Аймгийн татварын болон татварын бус, хөрөнгийн орлого 29,949,331.0 мянган төгрөг.

2. Улсын төсвөөс аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 11,070,422.4 мянган төгрөг.

3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн орлого 13,601,622.0 мянган төгрөг.

4. Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл 4,624,155.2 мянган төгрөг.

5. Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого 1,349,245.4 мянган төгрөг.

Арав. Орон нутгийн төсвөөс санхүүждэг аймгийн шууд харьяа болон аймгийн төвийн сумын төсөвт байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар, бусад сумын төсөвт байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 4 дүгээр сарын 01 хүртэл 40 хувиар, түүнээс хойш хугацаанд 20 хувиар, улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын төвийн суманд ажилладаг төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар, бусад сумдад ажилладаг төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 4 дүгээр сарын 01 хүртэл 20 хувиар 2024 оны төсвийн жилийг дуустал тооцож олгохыг аймгийн Засаг дарга (Б.Ариун-Эрдэнэ)-д даалгасугай.

Арван нэг. “Аймгийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Арван хоёр. “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Арван гурав. “Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Арван дөрөв. “Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Арван тав. “Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Арван зургаа. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийг баримтлан орон нутгийн төсвийн тэнцлийг бүрэн ханган ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Ариун-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБАТ

**Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх их засварын төсөл, арга
хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1. Шилжих их засвар:				250,000.0	75,000.0
1.1	Биеийн тамир спортын газрын "Б" заалны их засвар	2023	2024	250,000.0	75,000.0
2. Шинээр хэрэгжих их засвар				2,801,194.0	2,801,194.0
2.1	Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн спорт тоглоомын барилгын засвар (Булган, Булган сум)	2024	2024	580,000.0	580,000.0
2.2	Нэгдсэн эмнэлгийн лифт, хүлээн авахын хэсгийн засвар, тоноглол (Булган сум)	2024	2024	450,000.0	450,000.0
2.3	Биеийн тамир спортын газрын усан бассейн сургалтын төвийн барилгын засвар (Булган сум)	2024	2024	390,687.0	390,687.0
2.4	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын засвар, шинэчлэлт (Булган сум)	2024	2024	300,000.0	300,000.0
2.5	Соёлын төвийн барилгын их засвар (Орхон сум)	2024	2024	450,000.0	450,000.0
2.6	Аймгийн нөөцийн тэжээлийн агуулахын засвар, тохижилт (Булган сум)	2024	2024	30,000.0	30,000.0
2.7	Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын дээврийн засвар	2024	2024	235,507.0	235,507.0
2.8	Нэгдсэн эмнэлгийн гадна зам талбайн засвар, арчлалт	2024	2024	150,000.0	150,000.0
2.9	Эрүүл мэндийн төвийн засвар (Хутаг-Өндөр сум)	2024	2024	170,000.0	170,000.0
2.10	Иргэний танхимын сантехникийн засвар (Бугат сум)	2024	2024	20,000.0	20,000.0
2.11	Соёлын төвийн барилгын их засварын үлдэгдэл санхүүжилт (Баяннуур сум)	2024	2024	25,000.0	25,000.0
Нийт дүн				3,051,194.0	2,876,194.0

**Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө
оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр байршил, хүчин чадал	Хамрах салбар	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжүүлэх дүн
1. Шилжих төсөл, арга хэмжээ					1,736,000.0	388,000.0
1.1	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, нийтийн орон сууцнуудыг ээлж дараатай халуун усны системд холбох (Булган сум)	Дэд бүтэц	2021	2024	1,443,000.0	240,000.0
1.2	Ханжаргалант худалдааны төвөөс Хаан банк хүртэл явган зам шинээр барих (Булган сум)	Дэд бүтэц	2023	2024	150,000.0	75,000.0
1.3	Хүүхдийн Жаргалат зуслангийн гадна тохижилт, дулаан механик, сантехник, дотор заслын ажлын үлдэгдэл санхүүжилт	Нийгмийн салбар	2024	2024	18,000.0	18,000.0
1.4	Сумын төвийн цахилгаан хангамжийн 0.4-10 кв-ын ЦДАШ-ын нэмэлт ажил (Баяннуур сум)	Дэд бүтэц	2024	2024	25,000.0	25,000.0
1.5	Аймгийн ЗДТГ-ын лифт суурилуулах	Дэд бүтэц	2023	2024	100,000.0	30,000.0
2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ					4,116,678.0	4,116,678.0
2.1	Дашинчилэн ЭМТ-ийн орон нутгийн оролцоо (АХБТөсөл, оролцооны хөрөнгө)	Нийгмийн салбар	2024	2024	602,000.0	602,000.0
2.2	Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах	Дэд бүтэц	2024	2024	650,678.0	650,678.0
2.3	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих (Рашаант сум)	Дэд бүтэц	2024	2024	550,000.0	550,000.0
2.4	Сумын төвийн гэрэлтүүлэг (Хутаг-Өндөр сум)	Дэд бүтэц	2024	2024	100,000.0	100,000.0
2.5	Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын гадна засвар	Дэд бүтэц	2024	2024	620,000.0	620,000.0
2.6	Сумын төвийн гэрэлтүүлэг (Рашаант сум)	Нийгмийн салбар	2024	2024	120,000.0	120,000.0
2.7	Сумын төвийн гэрэлтүүлэг (Сайхан сум)	Дэд бүтэц	2024	2024	150,000.0	150,000.0
2.8	Гэр хороолол, гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх (Булган сум)	Дэд бүтэц	2024	2024	622,000.0	622,000.0
2.9	Сургуулийн биеийн тамирын талбай байгуулах (Дашинчилэн сум)	Нийгмийн салбар	2024	2024	320,000.0	320,000.0
2.10	Эрүүл мэндийн төвийн барилгын засвар (Бугат сум)	Эрүүл мэндийн салбар	2024	2024	282,000.0	282,000.0
2.11	Аймгийн баяр наадмын зардал	Нийгмийн салбар	2024	2024	100,000.0	100,000.0

3. Бараа, тоног төхөөрөмж					466,000.0	466,000.0
3.1	Хүнс, хөдөө аж ахуйн газрын суудлын жижиг автомашин	Хөдөө аж ахуйн салбар	2024	2024	28,000.0	28,000.0
3.2	Аймгийн татварын хэлтсийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	Төрийн захиргаа	2024	2024	15,000.0	15,000.0
3.3	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн техник хэрэгсэл	Нийгмийн салбар	2024	2024	8,000.0	8,000.0
3.4	"Жаргалант" хүүхдийн зуслангийн захиргаа аж ахуй, гал тогооны барилгын тоног төхөөрөмж	Нийгмийн салбар	2024	2024	75,000.0	75,000.0
3.5	Драйгер баталгаажуулах, дулаан хэмжилтийн эталон тоног төхөөрөмж	Хөдөө аж ахуйн салбар	2024	2024	25,000.0	25,000.0
3.6	Санхүүгийн хяналтын аудитын албаны хяналт шалгалтын автомашин	Төрийн захиргаа	2024	2024	50,000.0	50,000.0
3.7	Ахмадын амралт, сувилалын эмчилгээ сувилгааны тоног төхөөрөмж	Нийгмийн салбар	2024	2024	25,000.0	25,000.0
3.8	Усан шүүлтүүртэй халаалтын тогоо шинэчлэх 1,8мвт (Хутаг-Өндөр сум)	Дэд бүтэц	2024	2024	120,000.0	120,000.0
3.9	Аймгийн Засаг даргын тамгын газрын лифтны тоноглол, засвар	Дэд бүтэц	2024	2024	70,000.0	70,000.0
3.10	Соёлын үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах автомашин (Булган сумын Соёлын ордон)	Соёлын салбар	2024	2024	50,000.0	50,000.0
НИИТ					6,318,678.0	4,970,678.0

**Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр,
төсөл арга хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ				1,108,500.0	1,108,500.0
1.1	Ургац тээврийн авто замын засвар	2024	2024	50,000.0	50,000.0
1.2	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт	2024	2024	60,000.0	60,000.0
1.3	Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар	2024	2024	55,000.0	55,000.0
1.4	Зам, тээврийн хяналтын төвийн зардал	2024	2024	10,000.0	10,000.0
1.5	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Тэшиг сум)	2024	2024	150,000.0	150,000.0
1.6	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Бугат сум)	2024	2024	300,000.0	300,000.0
1.7	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Орхон сум)	2024	2024	300,000.0	300,000.0
1.8	Сумын төвийн зам засвар, арчлалт (Хутаг-Өндөр сум)	2024	2024	50,000.0	50,000.0
1.9	Булган сумын авто замын гэрлэн дохио шинээр тавих /ОБГ-ын уулзвар/	2024	2024	86,000.0	86,000.0
1.10	Булган-Мөрөн чиглэлийн замд байрлах Нисэхийн гүүрийн хамгаалалтын төмөр хашилт (Булган, Булган сум)	2024	2024	47,500.0	47,500.0
Нийт дүн				1,108,500.0	1,108,500.0

**Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх
төсөл арга хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

Д/д	Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
Шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ				
1	Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны тэмцлийн ажил (10100 га, Баян-Агт сум, Хутаг-Өндөр сум)	2023-2024	450,800.0	169,200.0
2	Цэвэр ус хангамжийн нэгдсэн систем шинээр байгуулах (Булган сум, 4-р баг)	2023-2024	500,000.0	250,000.0
3	Цэвэр усны даралтат цамхаг шинээр барих (Хангал сум)	2023-2024	228,850.0	128,435.6
4	Цэвэр усны даралтат цамхаг 2-р шатны ажил (Хангал сум)	2023-2024	234,000.0	121,101.2
5	Сумдын газар зүйн нэрийн тодруулалт, баталгаажуулах ажил (Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)	2023-2024	408,900.0	204,500.0
6	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт (25 га, Хангал сум, Сэлэнгэ суманд 2023 оны намрын ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлын үлдэгдэл)	2023-2024	66,500.0	33,200.0
Дүн			1,889,050.0	906,436.8
1. Усны нөөц хамгаалах, усан хангамжийг сайжруулах чиглэлээр				
7	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх тэмдэгжүүлэлт хийх (200 ширхэг)	2024-2024	40,300.0	40,300.0
8	Усны тоо бүртгэл, хөв цөөрөм байгуулах газрын судалгааны ажлыг зохион байгуулах	2024-2024	8,100.0	8,100.0
9	Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор Ойн хортны судалгааны ажил (800000 га, ой бүхий сумдад)	2024-2024	56,000.0	56,000.0
10	Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны тэмцлийн ажил (32500 га, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сайхан, Баян-Агт, Бугат, Орхон, Сэлэнгэ, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Булган сумдад)	2024-2024	975,167.0	975,167.0
11	Булган сумын 5 дугаар баг, 16, 17, 208 дугаар орон сууцны айл өрхөд хэрэгцээний халуун усны шугам татах (Булган сум)	2024-2024	350,000.0	350,000.0
12	Доройтсон бэлчээрийн газрыг нөхөн сэргээх, ойн зурвасын усалгааны зориулалтаар шинээр худаг гаргах (Баяннуур, Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Сайхан, Баян-Агт, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Орхон сум)	2024-2024	270,000.0	270,000.0
13	Булган Мээж ОНӨХХК-ний харьяа цэвэрлэх байгууламжийн насос худалдан авах (3ш)	2024-2024	105,000.0	105,000.0
14	Хүн ам, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр худаг гаргах (Булган сум, 2ш)	2024-2024	60,000.0	60,000.0

15	Хүн амын ундны усны эх үүсвэр болон төв усан сангийн хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлж хашаажуулах (Булган сум)	2024-2024	150,000.0	150,000.0
Дүн			2,014,567.00	2,014,567.00
2. Ой, цөлжилтийн талаар:				
16	2022 онд хийгдсэн ойн зурвас, ойжуулалт нөхөн сэргээлтийн арчилгаа, хамгаалалтын зардал (104 га, Дашинчилэн, Баяннуур, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Бугат, Хангал, Сэлэнгэ, Орхон сумдад)	2024-2024	117,400.0	117,400.0
17	Ойжуулалт нөхөн сэргээлт ажил хийх (37 га, Бугат, Хангал, Сэлэнгэ, Орхон, Хутаг-Өндөр)	2024-2024	100,000.0	100,000.0
18	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажил (8 га, Рашаант-2, Баяннуур-2, Гурванбулаг-2, Дашинчилэн-2)	2024-2024	180,000.0	180,000.0
19	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц, суулгац ургуулсан, бойжуулсан нөхөн сэргээж хамгаалсан иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах	2024-2024	100,000.0	100,000.0
20	Цөлжилт, элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор Рашаант суманд байгуулсан 2020, 2022 оны ойн зурвасанд механик хамгаалалт хийх (3га)	2024-2024	19,000.0	19,000.0
21	Хөл газрын ургамалтай механик аргаар тэмцэх	2024-2024	30,000.0	30,000.0
22	Ойн таваарлаг чанарыг нэмэгдүүлэх зорилгоор насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх (70 га, Бугат, Хишиг-Өндөр, Орхон, Хангал, Хутаг-Өндөр, Баян-Агт, Хангал, Сэлэнгэ сумдад)	2024-2024	30,400.0	30,400.0
23	"Хожуул" төслийг хэрэгжүүлэх (Булган сум)	2024-2024	30,000.0	30,000.0
24	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт	2024-2024	5,000.0	5,000.0
25	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын шороон зурвас байгуулах (64 га, Хутаг-Өндөр, Сэлэнгэ)	2024-2024	20,000.0	20,000.0
26	Хушин ойн талбайд төлөв байдлын судалгаа хийх (Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Бүрэгхангай, Бугат)	2024-2024	20,000.0	20,000.0
27	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор түймэр унтраах багаж хэрэгсэл авах (100 ширхэг үүргэвчин гал унтраагуур)	2024-2024	50,000.0	50,000.0
28	Булган аймгийн хэмжээнд 2024-2026 оны "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойн зурвас байгуулах ажлын зураг төсөл боловсруулах (100 га)	2024-2024	40,000.0	40,000.0
29	Сум дундын ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбай байгуулж арчлах (30 га)	2024-2024	29,100.0	29,100.0
30	Доройтсон хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	2024-2024	100,000.0	100,000.0
31	Байгалийн ургамлыг хамгаалах, хөрсний доройтлоос сэргийлэх зорилгоор Сансар 1, 2-р садны тохижилт (Булган сум)	2024-2024	340,000.0	340,000.0
32	Байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт (Булган сум)	2024-2024	1,000,000.0	1,000,000.0
Дүн			2,210,900.00	2,210,900.00
3. Газар, газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах хог хаягдлыг багасгах талаар				

33	Газрын хэвлийн хөрсөнд учруулсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох (эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр)	2024-2024	30,000.0	30,000.0
34	Хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах "Цэвэр орчин" аян, иргэдэд нөлөөллийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	2024-2024	50,000.0	50,000.0
35	Хог шатаах зуух нийлүүлэх (Рашаант, Хутаг-Өндөр, Булган, Хялганат)	2024-2024	694,000.0	694,000.0
36	Аймгийн Эвент болон бусад арга хэмжээнүүдэд зориулан зөөврийн 00 нийлүүлэх (40 ширхэг)	2024-2024	240,000.0	240,000.0
37	Сумдын төвлөрсөн хогийн цэгт ландфилын аргыг хэрэгжүүлэх жишиг зураг төсөв боловсруулах	2024-2024	20,000.0	20,000.0
38	Хатуу хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулах дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх хог түрж булах трактор нийлүүлэх (Бугат, Тэшиг, Баян-Агт Орхон)	2024-2024	320,000.0	320,000.0
39	Хатуу хог хаягдлыг ачиж, тээвэрлэх автомашин нийлүүлэх 2ш (Булган сум, Хангал сум)	2024-2024	260,000.0	260,000.0
40	Бохир соруулах тоноглогдсон автомашин нийлүүлэх (Булган, Хялганат, Хутаг-Өндөр, Рашаант, Сайхан сум)	2024-2024	350,000.0	350,000.0
41	Нэгдсэн эмнэлгийн аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх автоклав худалдан авах	2024-2024	80,000.0	80,000.0
42	ЕБС, мэргэжлийн байгууллагуудын химийн лабороторит ашиглагдаж байсан устгах шаардлагатай химийн бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	2024-2024	20,000.0	20,000.0
43	Сумын төвийн айл өрхийг хог ангилах ялгах хогийн савтай болгох (Булган сум 350ш)	2024-2024	332,500.0	332,500.0
44	Булган сумын төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг дарж булах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх (Булган сум)	2024-2024	75,000.0	75,000.0
45	Ариутгах татуургын систем угсрах ажил (Баян-Агт сум)	2024-2025	640,000.0	350,000.0
46	Бохир усны шугам сүлжээний угсралтын ажил (Сайхан сум)	2024-2024	290,000.0	290,000.0
47	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас оруулах 2 экспедици	2024-2024	5,000.0	5,000.0
48	Орчны бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг хамгаалах зорилгоор явган зам шинээр барих (Булган сум)	2024-2024	200,000.0	200,000.0
	Дүн		3,606,500.0	3,316,500.0
4. Биологийн төрөл зүйлийг хамгаалах				
49	Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээ авах	2024-2024	20,000.0	20,000.0
50	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2024-2024	20,000.0	20,000.0
51	Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө шинэчлэн боловсруулах	2024-2024	50,000.0	50,000.0
52	Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу хүрэн баавгайг аюулгүй болгох, амьд баригч, зөөвөрлөгч тор хийлгэх	2024-2024	5,300.0	5,300.0
53	Тарвага сэргээн нутагшуулах (Дашинчилэн сум)	2024-2024	18,000.0	18,000.0
	Дүн		113,300.00	113,300.00
5. Ногоон хөгжлийн бодлого, аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнүүд				

54	Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах (Айраг өдөр, Айрагны баяр, Хангинахын шугуй шагайн тойром ITM-2024)	2024-2024	250,000.0	250,000.0
55	"Алтаргана-2024" наадмын орчны бохирдлын менежментийн ажлыг зохион байгуулах	2024-2024	100,000.0	100,000.0
56	Аймгийн аялал жуулчлалын танилцуулга, газрын зураг англи, монгол хэлээр хэвлүүлэх, санамж, брошурыг 5 төрлөөр хэвлүүлэх	2024-2024	20,000.0	20,000.0
57	Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх зорилгоор төвийн бүсийн сургалт зохион байгуулах	2024-2024	30,000.0	30,000.0
58	Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд тодотгол хийх	2024-2024	40,000.0	40,000.0
Дүн			440,000.00	440,000.00
6. Бусад				
59	"Нүхэн жорлонгоос татгалзъя" аяныг өрнүүлж, "Хоггүй аялал" болзолт уралдаан, эко хэрэглээг нэвтрүүлэх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах	2024-2024	27,100.0	27,100.0
60	Хүүхэд залуучуудад экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах (1. Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Баяннуур 2. Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Могод, Орхон 3. Хангал, Сэлэнгэ, Хялганат, Бугат 4. Баян-Агт, Тэшиг, Хутаг-Өндөр, Сайхан, Булган)	2024-2024	24,000.0	24,000.0
61	Байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүсчилсэн зөвлөгөөн зохион байгуулах	2024-2024	30,000.0	30,000.0
62	Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны зардал	2024-2024	10,000.0	10,000.0
63	Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал	2024-2024	200,000.0	200,000.0
64	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалт хийх (хууль бус мод бэлтгэл, ой, хээрийн түймэр, ан агнуур, хог хаягдал, орчны бохирдол, ус, рашаан нөөц ашиглах, ашигт малтмал, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд хяналт үнэлгээ хийх)	2024-2024	20,000.0	20,000.0
65	Байгаль хамгаалагчдын 4 улирлын хувцас (35 ш)	2024-2024	189,000.0	189,000.0
66	Байгаль орчныг хамгаалах хяналт шалгалтанд шаардагдах туулах чадвар сайтай автомашин авах	2024-2024	150,000.0	150,000.0
67	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний ажлыг эрчимжүүлэх зорилгоор 16 сум, 1 тосгоны иргэдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2024-2024	30,000.0	30,000.0
Дүн			680,100.0	680,100.0
Нийт дүн			10,954,417.0	9,681,803.8